



**МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБОО**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Бага тойруу /15160/,
Сүхбаатрын талбай-9,
Утас: 70112128, Факс: (976) 70112128
E-mail: cmtu@mongol.net

**УИХ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Л.ЭНХНАСАН ТАНАА**

2025. 06. 10 № 03/295
танай _____ -ны № _____ -т

Нэр дэвшүүлэх тухай

"Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай"
2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн УИХ-09/6594 тоот албан бичгийн
хариуг хүргүүлж байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т
"Даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг
сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлээс гурван хүн" гэж заасны дагуу
Монголын Хөнгөн үйлдвэрийн ажилтны ҮЭ-ийн холбооны зөвлөх
Горчинсүрэнгийн Адъяаг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр
дэвшүүлэн холбогдох материалыг хүргүүлж байна.

Хувийг: -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн
даатгалын Үндэсний зөвлөлд

Хавсралт 2/1 хуудас

**ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**



Х.БУЯНЖАРГАЛ

**Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг
төлөөлсөн гишүүнд нэр дэвшигч**



Нэр:Горчинсүрэн **Адьяа**
Гэр бүлийн байдал:ам бүл 5
Төгссөн сургууль:

- 1987 онд Москва хотын үйлдвэрчний Эвлэлийн Хөдөлгөөний дээд сургууль-Хөдөлмөрийн эдийн засагч
- 2004 онд ОХУ-ын Москва хотын Хөдөлмөр Нийгмийн харилцааны академид-Эдийн засгийн ухааны доктор (PhD)

Ажил эрхлэлт:

Д/д	Албан тушаал	Огноо
1	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дэргэдэх Хөдөлмөр Нийгмийн Харилцааны дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх багш	2021 оноос
2	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга	2012-2021
3	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын орон тооны зөвлөх	2008-2012
4	УИХ-ын гишүүн	2004-2008
5	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч	1992-2004
6	Монголын худалдаа, үйлчилгээний ажилчдын ҮЭ-ийн холбооны дарга /МҮЭХ-ны төв байр/	1990-1992
7	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн байгуулалтын хэлтсийн эрхлэгч	1989-1990
8	Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлд аймаг хариуцсан зохион байгуулагч /МҮЭХ-ны төв байр/	1987-1989
9	Сүхбаатар аймаг хариуцсан хөдөлмөр хамгааллын улсын байцаагч /Сүхбаатар аймгийн ҮЭ-ийн зөвлөл/	1979-1982
10	Сүхбаатар аймгийн хүнсний үйлдвэрт засварчин-механик, эдийн засагч, үйлдвэрийн орлогч дарга /Сүхбаатар аймаг хүнсний үйлдвэр/	1974-1979

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН

ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн дор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр:Горчинсүрэн Нэр:Адьяа /Мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
1.2	Нэр дэвших хүсэлт гаргаж буй албан тушаал Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн гишүүнд
1.3	Нэр дэвшүүлсэн байгууллага Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо
1.4	Боловсрол 2004 он:ОХУ-ын Москва хотын Хөдөлмөр Нийгмийн харилцааны академид Эдийн засгийн ухааны доктор (PhD) 1987 он:Москва хотын үйлдвэрчний Эвлэлийн Хөдөлгөөний дээд сургууль, хөдөлмөрийн эдийн засагч бакалавр
1.5	Эрхэлсэн ажил 2021 он:МҮЭХ-ны дэргэдэх Хөдөлмөр Нийгмийн Харилцааны дээд сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн, зөвлөх багш ХНХДС-ийн захирал Г.Баярмаа, 99009192 2012 он:МҮЭХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга /МҮЭХ-ны төв байр/ 2008 он:Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын орон тооны зөвлөх Сайд Т.Ганди, 99113701 ХНХЯ-ны төв байр 2004 он:УИХ-ын гишүүн 1992 он:МҮЭХ-ны ерөнхийлөгч /МҮЭХ-ны төв байр/ 1991 он:Монголын худалдаа, үйлчилгээний ажилчдын ҮЭ-ийн холбооны дарга /МҮЭХ-ны төв байр/ 1990 он:МҮЭХ, Үйлдвэрчний эвлэлийн байгуулалтын хэлтсийн эрхлэгч 1987 он:МҮЭ-ийн төв зөвлөлд аймаг хариуцсан зохион байгуулагч /МҮЭХ-ны төв байр/ 1979 он:Сүхбаатар аймаг хариуцсан хөдөлмөр хамгааллын улсын байцаагч /Сүхбаатар аймгийн ҮЭ-ийн зөвлөл/ 1974 он:Сүхбаатар аймгийн хүнсний үйлдвэрт слесарь, механик, инженер /Сүхбаатар аймаг хүнсний үйлдвэр/
1.6	Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн таван жилд ямар нэгэн улс төрийн сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал эрхлээгүй.


1.7	Төрийн бус байгууллагын гишүүнчлэлийн талаар ТББ-д албан тушаал эрхэлж байгаагүй.
1.8	Нэр дэвшигч нь хэрэв байгаа бол доор дурдсан мэдээллийг бичнэ. -Дараах ном хэвлэл, судалгааны бүтээл дээр ажиллажээ. 2009 он:Эдийн засаг ба нийгмийн ардчиллын сурах бичиг 2009 он:ХБНГУ-ын Томас Майерийн бүтээл Нийгмийн ардчиллын ирээдүй Тус тус орчуулгын редактораар ажилласан. 2017 он:МҮЭХ-ны түүх 2017 он:МҮЭ-ийн хөдөлгөөний алтан номын хамтарсан бүтээлүүдийн зохиогч, ерөнхий редактор 2019 он:Оросын нэрт эдийн засагч А.И. Рофе-гийн “Хөдөлмөрийн зах зээл” сурах бичгийн ерөнхий редактор 2019 он:“Зохист хөдөлмөрийн тулгамдсан асуудлууд” сэдэвт судалгааны номын хамтран зохиогч, редактор 2024 он:ХБНГУ-ын Конрад-Аденаурын сангийн төслөөр МАОЭНХ-той хамтран “Зохист хөдөлмөр ба албан бус эдийн засгийг албажуулах нь” сэдэвт судалгааны ажил хийж зөвлөмж боловсруулан хэвлүүлж нийтийн хүртээл болгосон. Дараах хуулийн төсөл, дүрэм журам дээр ажилласан. Үүнд: 2017-2021 он:Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн УИХ-ын НББХ-ны ажлын хэсэгт уг хуулийг батлагдах хүртэл ажилласан. 2008 он:УИХ-аар батлагдсан ХАБЭА-н тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж уг хуулийг батлагдахад зохих хувь нэмрээ оруулсан. 2017-2021 он:Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороо, ХАБЭА-н үндэсний хорооны гишүүнээр ажиллах хугацаанд хөдөлмөр нийгмийн хамгааллын талаарх тус хороодоор хэлэлцэн баталсан бүх дүрэм, журмуудыг боловсруулахад оролцсон. -Сүүлийн 5 жилд олон улсын болон үндэсний хэмжээний хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаарх нийгмийн түншлэгч талуудын хурал зөвлөгөөнд дараах илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлсэн. Эдгээрт: 2019 он:Зохист хөдөлмөр эрхлэлтийг үндэсний хэмжээнд хөгжүүлэх, төлөвшүүлэхэд тулгамдаж буй асуудлууд 2020 он:Хөдөлмөрийн хүрээн дэх нийгмийн түншлэлийн зорилго, онолын үндэс, хөгжлийн зарчмууд 2020 он:ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэхэд даатгалын байгууллагуудын үүрэг оролцоо 2021 он:Хувь тэнцүүлсэн, өсөн нэмэгдэх татвар ногдуулах аргачлал, судлаачийн байр суурь 2021 он:Хөдөлмөрийн зах зээл дэх нийгмийн түншлэл 2022 он:Зохист хөдөлмөр ба бизнесийн удирдлагын шинэ хандлага, ХАБЭА-н зарим тулгамдсан асуудлууд 2023 он:Хөдөлмөрийн ирээдүй, тулгамдаж буй асуудлууд 2024 он:Зохист хөдөлмөр эрхлэлт, төр хувийн хэвшлийн түншлэлийн асуудлаарх дүгнэлт, санал, зөвлөмж 2023 он:Профессоруудын бүтээлийн өв номд хэвлэгдсэн, Улаанбаатар хот Уг ном ХНХДС-ийн номын санд бий. 2024 он:Достойны труд и новые подходы к управлению бизнесом, некоторые актуальные вопросы охраны труда Эдгээр илтгэлийн материалууд номд хэвлэгдэн гарсан.

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1

- НДҮЗ-ийн даатгуулагчдын төлөөлсөн гишүүнээр сонгогдсон нөхцөлд НД-ын ерөнхий хуулиар НДҮЗ-д олгосон чиг үүргийг хэрэгжүүлж даатгуулагчдын эрх ашгийг төлөөлөн нийгмийн түншлэгч талуудтай ажил хэрэгчээр хамтран ажиллах болно. НДҮЗ-ийн гишүүний хувьд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, даатгуулагч төвтэй нийгмийн даатгалын үйлчилгээг үндэсний хэмжээнд хөгжүүлэх, төлөвшүүлэхэд өөрийн мэдлэг, туршлагаа зориулах болно. Төрөөс НД-ын тогтолцоог даатгуулагчид ээлтэй болгох чиглэлээр хийхийг зорьж буй шинэчлэлийг дэмжиж холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, НД-ын үйлчилгээг даатгуулагчдын хүсэл, сонирхолд нийцсэн байдлаар хөгжүүлэх, даатгалын сангуудаас шимтгэл төлөгч-даатгуулагчдад үзүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний хүрээг хөгжингүй орнуудын жишгээр нэмэгдүүлэхэд онцгой анхаарах болно. Тухайлбал ҮОМШӨ-ний даатгалын сангийн удирдлага зохион байгуулалтыг Германы туршлагаар өөрчлөн осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, даатгуулагч осол, өвчлөлд өртсөн тохиолдолд нөхөн сэргээх даатгалын байгууллагын үндсэн үйлчилгээг хөгжүүлэх, шимтгэл төлөгч-ажил олгогчдод даатгалын сангаас үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгохыг зорьж байна.
- Цаашид НД-ын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж нь даатгуулагчийн зөвхөн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх зарчмыг тууштай хэрэгжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн шинэчлэлийг шуурхай хийхэд анхаарна. Тэтгэврийн гурван давхаргат тогтолцоог дэмжиж тэтгэвэр авагч амьжиргаагаа хангахуйц тэтгэвэртэй байх нөхцөлийг шуурхай бүрдүүлэхийн төлөө ажиллана.
Мөн тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд шилжих бодлогын хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх, бэлтгэл хангах, үндэсний хөтөлбөр боловсруулах асуудал санаачилна.
- Нийгмийн даатгалын тогтолцооны бие даасан, хараат бус байдлыг хангаж өөрийн удирдлагыг бэхжүүлэхэд анхаарна.
- НД-ын тогтолцоог улс төрийн нөлөөлөл, сонгуулийн амлалтуудаас ангид байлгах чиглэлээр ажиллана.
- НД-ын тогтолцооны орц ба гарц буюу шимтгэл төлөгчид, тэтгэвэр, тэтгэмж олголтод шударга ёсны зарчмыг баримтлах
- Олон улсад хуримтлалын тогтолцоог нэвтрүүлсэн орнуудад тулгамдаж буй бэрхшээлийг судлан үзэх
- Орлогыг нэмэгдүүлэхийн тулд баялгийн сантай холбох тохиолдолд тодорхой хязгаарлалт тавьж тогтвортой байдлыг хангахад онцгойлон анхаарах
- Өндөр насны тэтгэвэр авагсдын тэтгэврийг улс орны эдийн засгийн хөгжилтэй уялдуулан нэмэгдүүлэх аргачлал боловсруулж өндөр настнуудад эх орны хөгжлийн үр шимийг тэгш хүртээх зорилго тавьж ажиллана.
- ҮОМШӨ-ний даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах /Цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан осол, гамшиг олширч буйг харгалзан/
- Даатгуулагч төвтэй НД-ын үндэсний тогтолцоог төлөвшүүлэхэд даатгуулагчид, шимтгэл төлөгчдийн оролцоо, хөндлөнгийн хяналтыг

	нэмэгдүүлэх, бүх шатны НД-ын байгууллагуудын үйл ажиллагааг ил тод байдлыг дээшлүүлж тэдний даатгуулагчидтай ажиллах, зөвлөн туслах ажлын арга барилыг эрс шинэчлэхэд НДҮЗ-ийн даатгуулагчдыг төлөөлсөн гишүүд онцгой анхаарна. • НД-ын сангийн орлого бүрдүүлэлтийг сайжруулахын тулд иргэдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг өргөжүүлэх, үүнд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. Ялангуяа хувийн хэвшлийн жижиг дунд аж ахуйн нэгжүүд, албан бус салбарт ажиллагсдад онцгой анхаарал хандуулна. Үндэслэл: МҮЭХ нь НД-ын ерөнхий хуулийн 35.1.2 заалтаар олгосон эрхийн дагуу нийт ажилтны дийлэнх олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн НДҮЗ-ийн гишүүнээр миний биеийг сонгох санал дэвшүүлсэн үндэслэл нь: Хөдөлмөрийн хүний хөдөлмөрлөх эрх ашгийг төлөөлөн хамгаалах, чиглэлээр олон жил ажилласан туршлага, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудлаар мэргэшсэн байдал, мөн хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагад ажилласан туршлага, эрдмийн зэрэг цол зэргийг минь харгалзан үзэж итгэл хүлээлгэсэн гэж үзэж байна. УИХ-ын НББХ энэ итгэлийг дэмжвэл миний бие НДҮЗ-ийг бүрдүүлэгч нийгмийн түншлэлийн талуудтай ажил хэрэгчээр хамтран ажиллах болно.
--	--

Хүсэлт гаргагч: Г.Адъяа
Эцэг/эхийн нэр: Горчинсүрэн
Өөрийн нэр: Адъяа
Майл хаяг: cmtu.adiya@gmail.com
Утасны дугаар: 99990831
Гарын үсэг: 

2025 оны 06-р сарын 12
Улаанбаатар хот